



Сургалтын технологийн хөгжилд сургалтын менежерийн үүрэг, оролцоо (Орон нутгийн жишээн дээр)

Цэдэн-Очир Пагмажав 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Яйш Шийлэгмаа 

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Баатар Лхагвамаа 

Улаанбаатар Эрдэм Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Пагмажав, Ц., Шийлэгмаа, Я., Лхагвамаа, Б. (2026). Сургалтын технологийн хөгжилд сургалтын менежерийн үүрэг, оролцоо (Орон нутгийн жишээн дээр). *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 31(1). <https://doi.org/10.56380/mjer.v31.1.1>

The role and involvement of the Training manager in the development of learning technology (based on a local example)

Pagmajav Tseden-Ochir 

Mongolian National University of Education

Shiilegmaa Yaish 

Mongolian National University of Education

Lkhagvamaa Baatar 

Ulaanbaatar erdem University

To cite this article:

Pagmajav, Ts., Shiilegmaa, Y., Lkhagvamaa, B. (2026). The role and involvement of the Training manager in the development of learning technology (based on a local example). *Mongolian Journal of Educational Research*, 31(1). <https://doi.org/10.56380/mjer.v31.1.1>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Сургалтын технологийн хөгжилд сургалтын менежерийн үүрэг, оролцоо
(Орон нутгийн жишээн дээр)

Цэдэн-Очирын Пагмажав, Яйшийн Шийлэгмаа, Баатарын Лхагвамаа

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2025.04.25

Засаж сайжруулсан: 2025.11.09

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2026.01.26

Түлхүүр үг:

Багшийн заах арга зүй

Интеграц

Туршилт

Үр дүн

ХУРААНГУЙ

Сургалтын технологи нь сургалт, үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг бөгөөд хүүхэд бүрд чанартай боловсрол олгоход чиглэсэн байдаг. Сургалтын технологийг сайжруулах хамгийн эхний алхам бол багшийг чадваржуулах асуудал юм. Энэ асуудалд сургуулийн удирдлага тэр дундаа багшийн хөгжилд хамгийн ойр зөвлөн туслах, удирдлагаар хангах үүрэгтэй сургалтын менежер чухал нөлөөтэй байдаг. Гэвч менежер дээрх үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй статистик мэдээ тайлан гаргаж судалгаа авах, гэнэтийн цаг үеийн ажлуудад ихэнх хугацаагаа зарцуулаад сургалтын технологийг хэрэгжүүлэх, сайжруулах ажил алдагдаж байгааг сургуулийн үйл ажиллагаа болон олон судалгааны үр дүнгээс харж болно. Тэгвэл энэ асуудлыг шийдэх боломжтойг сургалтын менежер багш нартайгаа хамтран хэрэгжүүлсэн судалгаат интеграц хичээлийн туршилт судалгааны эерэг үр дүн харуулж байна.

T-test статистик шинжилгээ хийхэд $p < 0.01$ нь интеграц хичээлийн арга зүйг ашиглах нь статистикийн хувьд ач холбогдолтойг нотолсон. Судалгаанаас интеграц хичээлийн арга зүй нь суралцагчдын сурлагын амжилт, багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхээс гадна сургалтын менежерийн мэргэжлийн болон хувийн ур чадварыг нэмэгдүүлэхэд үр дүнтэйг харуулав.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Баатарын Лхагвамаа

Улаанбаатар эрдэм Их Сургууль

Email: Lkhagii0133@gmail.com

The role and involvement of the Training manager in the development of learning technology
(based on a local example)

Pargamjav Tseden-Ochir, Shiilegmaa Yaish, Lkhagvamaa Baatar

Article information

Article history:

Received: Apr 25, 2025

Revised: Nov 09, 2025

Accepted: Jan 26, 2026

Keywords:

Teaching methodology

Integration

Testing

Results

ABSTRACT

Learning technology plays a central role in ensuring equitable access to quality education for every learner. Accordingly, the first step in strengthening learning technology is the empowerment of teachers. Within this process, school management, particularly the training manager, who is responsible for providing close mentoring and guidance for teacher professional development, plays a critical role. However, evidence from school practice and research indicates that training managers are often unable to fulfill these core responsibilities, as they spend most of their time on statistical reporting, research tasks, and unforeseen assignments, resulting in limited attention to the implementation and continuous improvement of learning technology.

Findings from a pilot study on integrated lessons conducted collaboratively by training managers and teachers demonstrate that this challenge can be addressed effectively. T-test statistical analysis indicated that $p < 0.01$, confirming that the application of integrated lesson methodology is statistically significant. The study further demonstrates that the integrated lesson approach improves students' academic achievement, enhances teachers' professional skills, and strengthens the professional and personal capacities of training managers in practice.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Lkhagvamaa Baatar

Ulaanbaatar erdem University

Email: Lkhagii0133@gmail.com

УДИРТГАЛ

Сургалтын технологи нь сургалт, үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг бөгөөд хүүхэд бүрд чанартай боловсрол олгоход чиглэсэн байдаг. Сургалтын технологийг сайжруулах хамгийн эхний алхам бол багшийг чадваржуулах асуудал юм. Үүнд сургуулийн удирдлага тэр дундаа багшийн хөгжилд хамгийн ойр зөвлөн туслах, удирдлагаар хангах үүрэгтэй сургалтын менежер чухал нөлөөтэй. Энэ талаар БШУЯ-ны сайдын 2023 оны А/525 дугаартай тушаалаар баталсан сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагад тодорхой тусгасан байдаг. Тухайлбал, дээрх тушаалын 2.1-д сургалтын менежерийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн нийтлэг шаардлагад сургалтын менежер нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.2-ын дагуу сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, багшид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, багш нарын хамтын ажиллагааг дэмжих замаар сургалтын чанарыг сайжруулах үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих мэдлэг, чадвар, хандлагатай байна гэж заасан байна. Гэвч сургалтын менежер дээрх үндсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй статистик мэдээ, тайлан гаргах, судалгаа авах, гэнэтийн цаг үеийн ажлуудад ихэнх цагаа зарцуулдаг нь сургалтын технологийг хэрэгжүүлэх, сайжруулах ажил алдагдаж байгааг сургуулийн үйл ажиллагаа болон олон судалгааны үр дүнгээс харж болно. Тухайлбал, сургалтын менежерийн ажлын байрны үндсэн зорилтын хүрээнд хамгийн их хийдэг ажил нь статистик мэдээ тайлан гаргаж, судалгаа авдаг байна. Мөн цаг үеийн гэнэтийн ажлыг ихээр гүйцэтгэж байгааг “ЕБС-ийн сургалтын менежерийн ажлын чиг үүргийн өөрчлөлт ба хэрэгжилт” судалгааны үр дүнгээс харж болно (Ариунгэрэл, 2020). Тиймээс сургалтын менежер үндсэн ажлын чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл боломж дутмаг сургалтын технологийг сайжруулахад чиглэсэн багш нарын мэргэжил, арга зүйг дээшлүүлэх, суралцагчийн суралцахуйг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд уг судалгааг хийлээ.

Ц.Пагмадулам нарын “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн хөгжих хэрэгцээний судалгаа”-д багш, суралцагчдыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага хамгийн их байгааг тогтоосон бөгөөд сургалтын менежерийн ажлын ачааллаас үүдэн тэдний үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд бэрхшээл тулгарч байгаа нь сургалтын менежерийн хөгжих боломжийг хязгаарлаж, улмаар багшийн хөгжил, сургалтын чанарт ч нөлөөлж байна.


Хүснэгт 1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн хөгжих хэрэгцээний судалгаа

Ур чадварууд	Сургалтын менежер		Багш	
	Хэрэгцээ	Эрэмбэ	Хэрэгцээ	Эрэмбэ
Багшийг хөгжүүлэх	4.25	1	1.84	1
Суралцагчийг хөгжүүлэх	3.73	2	1.73	2
Бодит үр дүн, үйл ажиллагаандаа оношилгоо, шинжилгээ хийх	2.93	3	1.07	8
Үр дүнд боловсруулалт хийх	2.74	4	0.98	10
Багш суралцагчийнхаа хөгжлийн хэрэгцээг тодорхойлох	2.52	5	1.23	4
Технологи ашиглах	2.06	6	0.38	18
Хүн нэг бүрийг оролцуулах	2.01	7	0.90	11
Өөрийгөө хөгжүүлэх	1.94	8	0.26	19
Нөөцийн давуу талыг ашиглах	1.93	9	0.87	12
Мэдээлэл ашиглах, задлан шинжлэх	1.87	10	0.00	20
Үйл явцыг удирдаж шийдвэр гаргах	1.38	11	0.60	17
Бусдад урам зориг төрүүлэх	1.16	12	1.50	3
Бүтээлч, санаачилгатай, ажил хэрэгч байх	1.15	13	0.62	16

Эх сурвалж: Пагмадулам, Ц, Өлзийсайхан, Г (2023)

Иймд сургалтын менежер ажлын байрныхаа үндсэн зорилтын хүрээнд багшийн мэргэжлийн болон арга зүйн хөгжлийг дэмжихийн тулд сургалтын технологийн шинэлэг арга, аргачлалыг

боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнийг батлах нэгэн жишээ нь орон нутгийн сургуулийн сургалтын менежерүүдийн туршилт судалгааны үр дүн юм. Сургалтын менежер сургалт, үйл ажиллагаанд шинэлэг технологи туршин нэвтрүүлснээр багшийн мэргэжлийн ур чадвар нэмэгдэж суралцагчийн сурлагын амжилт дээшлэн сургалтын чанарт бодитой хувь нэмэр оруулна хэмээн таамаглаж байна (Зураг 1).



Зураг 1. Үр дүнгийн зураглал

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙАЛ

Сургалтын технологи хэмээх нэр томъёо 1960-аад оноос сургалт, үйл ажиллагаанд техник хэрэгсэл, программчилсан сургалтыг ашиглахтай холбоотойгоор үүссэн. Үүнээс хойш олон улсын болон үндэсний эрдэмтэн судлаачид сургалтын технологийн мөн чанар, зорилго, хэрэгжүүлэх арга зүйг өөр өөрийн өнцгөөс тодорхойлж, түүний онолын үндэс, хэрэглээний чиглэлийг өргөжүүлэн судалж иржээ.

Оросын сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменскийн анги, хичээлийн систем бий болсноор улам гүнзгийрэн хөгжсөн байна. Эрдэмтэн Д.Ванчинсүрэн “Хүний боловсрол, хүмүүжил, төлөвшлийн горимын тухай ойлголт өөрөөр хэлбэл, хүнээр хүн хийх ухаан буюу хүний гарыг ганзаганд, хөлийг дөрөөнд хүргэх нийгмийн тогтолцоо” хэмээн үзжээ. Мөн түүнчлэн сургалтын технологи нь нэг цагийн дотор гүйцэтгэх багш, шавийн үйл ажиллагааны мөрдөх горимыг тодорхойлсон ухагдахуун хэмээсэн байна. Энэ асуудлаар судлаач Г.Эрдэнэ-Очир “Сургалтын технологи гэдэг нь сургууль, боловсролын байгууллагын өмнө тавьсан зорилго түүнийг хэрэгжүүлэхэд баримталдаг зүй тогтол, зарчим, зохион байгуулах хэлбэр, аргын түгээмэл дэс дараа, зохистой хувилбар” хэмээн тайлбарласан нь бий.


Оросын эрдэмтэн Н.Ф.Талызина “Технологи бол нэг талаас ур чадварын шинжлэх ухаан, нөгөө талаас бүтээгдэхүүнийг янз бүрийн аргаар боловсруулах дамжлага юм. Мөн удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулсан үйлийг гүйцэтгэх хамгийн оновчтой эрэмбэ, дэс дараа, түүний хувилбар” гэж, Европын сургалтын онолчид “Сургалтад дэвшигдсэн зорилт түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зүй тогтол, зарчим зохион байгуулах хэлбэр” гэж, АНУ-ын эрдэмтэн Б.Блум “Сургалтын материалыг эзэмшихэд зарцуулсан хугацаа” хэмээн тус тус тодорхойлсон байна. Харин Японы эрдэмтэн Т.Сакамото “Сургалтыг системчлэх явдал” гэсэн өөр өнцгөөс тайлбарласан. Сургалтын технологийн шинэчлэлийн семинарт зориулсан баримт бичигт “Сургалтын технологи гэдэг нь бие хүний буюу суралцагчдын мэдлэг, дадлага, хандлагын өөрчлөлтийг буюу чанарын хувиргалтын үйл явцыг зохион байгуулах соёл буюу ур ухаан, арга зам” хэмээн тодорхойлжээ. Дээрх тодорхойлолтуудаас “сургалтын технологи” хэмээх ойлголт нь зөвхөн сургалтын арга, хэрэгслийн хэрэглээгээр хязгаарлагдахгүй, сургалтын зорилго, агуулга, арга зүй, хэрэгжилт, үнэлгээ зэрэг бүх үе шатыг уялдуулсан цогц системийн үйл явц болох нь тодорхой харагдаж байна.

Сургалтын технологи нь сургалт, үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэйгээр зохион байгуулах, хүний хөгжил, төлөвшлийг зорилтот түвшинд хүргэх, арга зүй, хэрэгсэл, үйл явцын оновчтой дараалал болон хэлбэрийн сонголтыг боловсруулах, багш, суралцагчийн хамтын үйл ажиллагааг үр дүнтэй болгох зэрэг шинж чанартай юм.

Иймд сургалтын технологийг ерөнхийд нь “суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын хөгжлийг тодорхой зорилгод чиглүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах багшлахуй, суралцахуйн цогц үйл явц” хэмээн үзэх боломжтой байна.


Багшлахуйн шинэ чиг хандлага нь багшийг судлаач байх, хөгжлийнх нь онцлог, хэрэгцээг харгалзан суралцагч төвт арга барилаар ажиллахыг шаардаж байна. XXI зууны суралцагчид өөрчлөлтөд дасан зохицох, бэрхшээлийг даван туулж асуудлыг шийдвэрлэх, мэдлэг бүтээх идэвхтэй аргад суралцах шаардлагууд тулгарч байгаа тул багш нар суралцагч төвт арга зүйг эзэмшиж хэрэгжүүлэх, сургалтын технологио сайжруулах асуудал байсаар байна.

Дээрх асуудлын нэг шийдэл нь багш нараа дээрх чиг хандлага руу хөтлөх, хөгжүүлэх үүрэг сургалтын менежерт ногдуулж, үүнийг бодлого, үйл ажиллагаанд тусган ажиллах нь зайлшгүй чухал байна. Энэ хүрээнд орчин үеийн сургалтын загвар, дизайн (Learning Model & Design), суралцагч төвтэй, мэдлэг бүтээлгэх сургалтын технологийг судалж, олон загвар, дизайн боловсруулан сургалтад хэрэглэх хэрэгтэй байна. Сургалтын дизайн нь боловсрол, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй, найдвартай байдлаар боловсруулахтай холбоотой арга техник, үйл ажиллагааны тогтолцоо юм. (Gustavus & Branch, 2002)



Зураг 2. Суралцагч төвтэй дизайн

Суралцагч төвтэй дизайн нь сургалтын агуулга, үйл явц, орчныг суралцагчийн онцлог, хэрэгцээ, сонирхол, өмнөх туршлага, хөгжлийн түвшинд нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх цогц загварыг ашиглах боломжтой. Мөн орчин үеийн сургалтын менежментийн цикл болох PDCA нь сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулах зорилготой менежментийн үе шаттай, давтагдах үйл явц юм. Энэхүү туршилт судалгааг PDCA мөчлөгийн зарчимд тулгуурлан зохион байгуулсан. Энэ загвар нь аливаа үйл ажиллагааг оновчтой төлөвлөж, гүйцэтгэлийг хянаж, үр дүнг дүгнэн, дараагийн шатанд сайжруулалт хийхэд чиглэдэг.



Зураг 3. Сургуулийн менежментийн цикл

Сүүлийн жилүүдэд удирдах ажилтан тухайн сургуулийн амжилтад хэрхэн нөлөөлж байгаад анхаарал хандуулж түүнийг судлах болсноор удирдах ажилтныг бэлтгэх асуудал олон улсын хэмжээнд ч чухлаар тавигдаж байна. Судлаачид удирдах ажилтны талаар багагүй судалсан ч сургуулийн дунд шатны менежерүүдийн ажлын талаар харьцангуй бага судалжээ (Grootenboer, 2018, p.1; Seo et al., 2021, p.218). Учир нь сургуулийн удирдах ажилтны ур чадварын талаар судалсан судалгааны ихэнх нь захирлуудад төвлөрдөг (Brent, Deangelis, & Surash, 2014, p.883; Боловсролын хүрээлэн, 2013, p.3). Захирал нь багш мэргэжлээс ялгаатай бөгөөд хичээл, сургалтын үйл ажиллагаа төдийгүй сургуулийн менежмент, бусад сургууль, байгууллагатай хамтран ажиллах зэрэг ур чадварыг эзэмшсэн байх (OECD, 2007, p.247), эдгээрийг тасралтгүй хөгжүүлж байх шаардлагатай байна (Pont et al., 2008, p.136). Ерөнхий боловсролын сургуулийн хөгжилд захирлаас гадна чухал үүрэгтэй албан тушаал нь дунд шатны менежер буюу дэд захирал, сургалтын менежер, ахлах багш албан тушаал байдаг (OECD, 2008, p.78).

Сургуулийн захирал, сургалтын менежер нь албан тушаалтны хувьд шаталсан шинжтэй ч албан тушаалын тодорхойлолтын чиг үүрэг нь эргэлзээтэй, давхардалтай зүйлүүд багагүй байдаг (Seo, et.al., 2021, p.218; Grootenboer, 2018, p.120). Түүнчлэн, захирал болон дунд түвшний менежерүүдийн чиг үүрэг хоорондоо уялдаа холбоотой байдаг ч тэдний манлайлал нь өөр байдаг. Өөрөөр хэлбэл дунд шатны менежерийн чиг үүрэг нь сургалтын үйл ажиллагаа, харилцаа зэргээрээ захирлынхаас ялгаатай (Grootenboer, 2018, p.1). Сургуульд захирлын чиг үүрэг тодорхой бөгөөд тэд эцсийн шийдвэрийг гаргадаг боловч сургалтын менежер нь захирлын чиг үүрэгт туслах, зарим тохиолдолд орлон гүйцэтгэх, сургалтын үйл ажиллагааг зохицуулах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг (Grootenboer, 2018, p.3).

Манай улсын хувьд ерөнхий боловсролын сургалтын менежерийн албан тушаалын тодорхойлолт 2003 оноос хойш 4 дэх удаагаа өөрчлөгдсөн бөгөөд (Ариунгэрэл, 2020, p.74) тэдний ажлын үндсэн чиг үүргийн дийлэнх нь шинэчлэгдсэн байна. Ажлын чиг үүрэг өөрчлөгдөхийн хэрээр сургалтын менежерүүдийн эзэмшсэн байх ур чадварууд өргөн хүрээтэй болж байна. Тиймээс манай улс ч сургуулийн манлайлалд чухал субъект болох сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах, багшийг хөгжүүлэх чиг үүрэг бүхий сургалтын менежерийн ур чадварт анхаарал хандуулах шаардлага байна. Учир нь бид сүүлийн 30 жилд сургуулийн удирдах ажилтныг бэлтгэх тогтолцоогүй явж ирсэн бөгөөд сургалтын менежерийн ажлын чиг үүрэг, хөгжлийн талаар хийсэн судалгаа хангалттай бус байна. Харин сургуулийн захирлын талаар судалсан судалгаа багагүй байна. Тухайлбал Нарантуяа (2004, p.14), Рэнцэнханд (2010), Боловсролын хүрээлэн (2008, p.5), Боловсролын хүрээлэн (2013), Бямбажав (2016, p.65), Уянга (2016, p.157), Наранчимэг (2017, p.20), Ариунгэрэл (2020) нарын судалгаануудын дийлэнх нь сургуулийн захирал, тэр дундаа манлайлах ур чадварын талаар судалсан байна.


Манай улсад 1921 онд сургууль анх байгуулагдсанаар “сургагч түшмэл” гэх ойлголт гарч, улмаар “хичээлийн эрхлэгч”, “сургалтын технологич”, “сургалтын менежер” гэх нэршлүүд бий болж, тэр үеэс сургалтын менежерийн чиг үүрэг ба ур чадварууд тодорхойлогдож байжээ (Рэнцэнханд, 2010, p.33-40). Хичээлийн эрхлэгчийн ажил үүргийг 1991 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр, 2003 оноос ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлж ирсэн бол түүнээс

хойш ажлын байрны тодорхойлолт 2007, албан тушаалын тодорхойлолт 2019, 2020, 2023 онуудад өөрчлөгдөн шинэчлэгджээ.

АРГА ЗҮЙ

2023-2024 оны хичээлийн жилд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүд ажлын үндсэн үүргийн дагуу багшийн мэргэжлийн арга зүйг сайжруулах, сургалтын чанарын нэмэгдүүлэх зорилгоор шинэлэг технологийг орон нутгийн сургуульдаа туршин нэвтрүүлэх судалгаат интеграц хичээлийг зохион байгуулсан. “Багш нарын хамтын ажиллагаа-хичээл хоорондын интеграцчилал” сэдэвтэйгээр бага, дунд ангийн сургалтын агуулгын залгамж холбоонд тулгуурлан нэг хичээлийн жилийн турш зохион байгуулж, үр дүнг SPSS version 26 программаар боловсруулан тооцсон бөгөөд судалгаанд Quasi-Experimental (хагас туршилт)-ын дизайныг ашиглалаа.

Судалгаат интеграц хичээлийн үйл ажиллагааны цикл нь PDCA зарчмын дагуу явагдсан бөгөөд дараах үе шаттай зохион байгуулсан.



Зураг 4. PDCA судалгаат хичээл зохион байгуулсан үе шат

Судалгаат интеграц хичээлийг Хөвсгөл аймгийн Мөрөн сумын хоёр сургуулийн бага, дунд ангийн 4 сургалтын менежер санаачлан зохион байгуулсан. Уг туршилт судалгаанд бага, дунд ангийн 46 багш, туршилтын бүлэгт 2 бага ангийн 68, 2 дунд ангийн 44, нийт 112 суралцагч, хяналтын бүлэгт 2 бага, 2 дунд ангийн, нийт 106 суралцагч хамрагдлаа. Судалгаат интеграц хичээлээ улам сайжруулах, тухайн арга зүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор хичээлийн жилийн III улирлаас байршлаараа ойролцоо 3 сумын 3 сургалтын менежер, 15 багш, 6 ахмад багшийг урьж, хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Хүснэгт 2. Хөвсгөл аймгийн түүврийн эх олонлог

	Сургууль	Сургалтын менежер	Багш	Суралцагч
Эх олонлог	8	21	618	2245

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2018)

Хүснэгт 3. Судалгааны түүврийн хэмжээ

Үзүүлэлт	Онолын үндэслэл
Түүвэрлэлтийн арга	Түүвэр нь олонлогийн бүтэцтэй уялдаж, төлөөлөл сайтай
Итгэлцлийн түвшин	95% → судалгааны үр дүнг ерөнхийлөх боломжтой
Алдаа	±5% → академик судалгаанд тохиромжтой
Хэмжээ	ЕБС N =8, n ≈ 2, CM N =29, n ≈ 4, Багш N =618, n ≈ 46, Сурагчид N =2245, n ≈ 218 статистикийн баталгаатай

SPSS программд ашиглагддаг хамгийн нийтлэг түүвэр тооцох арга болох Cochran-ийн томъёо ашиглан $ZZZ = 1.96$ (95% итгэлцлийн түвшинд), $ppp = 0.5$ (хамгийн өндөр дисперс, хамгаалалттай), $eee = 0.05$ (алдааны түвшин буюу 5%) байхаар тооцоолон гаргасан.

Уг түүврийн хүрээнд судалгаат-интеграц хичээл зохион байгуулсны дараа буюу хичээлийн жилийн төгсгөлд гарсан үр дүнг хэмжихийн тулд дараах судалгааг авч SPSS программаар шинжилгээ хийн үр дүнг тооцлоо. Үүнд:

- Суралцагчдын сурлагын амжилт
- Багшийн мэргэжлийн заах ур чадвар
- Сургалтын менежерийн үндсэн ажлын үр дүн, хөгжил

Хяналтын бүлгийн суралцагчдад тухайн хичээлийг үндсэн агуулгын хүрээнд уламжлалт аргаар зааж хичээлийн төгсгөлд үнэлгээ авч туршилтын бүлгийн суралцагчийн үнэлгээтэй харьцуулан сурлагын ажилтыг тооцсон. Өөрөөр хэлбэл, хичээлийн жилийн эхнээс туршилтын ангид судалгаат-интеграц хичээл, хяналтын ангид сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд уламжлалт аргаар хичээл, сургалтыг зохион байгуулсан. Хичээлийн цагийг БСШУС-ын сайдын 2019 оны А/491 дугаартай тушаалын дагуу төлөвлөсөн.

Сургалтын менежер хичээлийн жилийн эхэнд “Багш нарын хамтын ажиллагаа-хичээл хоорондын интеграцчилал” судалгаат хичээлийн зохион байгуулалт, хуваарь, ажлын төлөвлөгөө гарган зорилтот багш нарт сургалт зохион байгуулан сургалтын хөтөлбөрийн шинжилгээ хамтран хийж хичээлийн бэлтгэл хангуулсан. Хүснэгт 4-д дараах сургалтын хөтөлбөрийн шинжилгээг жишээ болгож үзүүлж байна.

Хүснэгт 4. Бага, суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн харилцан холбоо ахих түвшинд

Бага боловсролын сургалтын хөтөлбөр	Суурь боловсролын сургалтын хөтөлбөр
2.1. Хүүхэд бүрийг авьяас, сонирхол, хувийн онцлог шинжийг нээх, суралцахуйг нь дэмжих, хөгжүүлэх үндэс болох;	2.1. Сурагч бүрийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг дэмжсэн, бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд тулгуурласан байх;
2.2. Агуулга нь шурган бүтцээр гүнзгийрэх, өргөсгөх, залгамж холбоотой, тасралтгүй, хүүхдийн хөгжил, төлөвшлийн ахиц дэвшлийг хангахуйц байх;	2.2. Бага боловсролын агуулгатай адил
2.3. Сургалтын арга зүй нь тухайн насны хүүхдийн нас сэтгэхүй, танин мэдэхүйн хөгжлийн онцлогт нийцсэн сурах арга барил, мэдлэг чадвар эзэмших, хандлага төлөвшихөд чиглэсэн байх;	2.3. Сургалтын арга зүй нь шинжлэн судлах болон сурах арга барил, бие даан бүтээлчээр суралцахад дэмжлэг болохуйц байх;
2.4. Мэдлэгийг хэрэглээ болгох, сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах, сургалтын орчныг бүрдүүлсэн байх;	2.4. Бие даах буюу хамтран суралцах, сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах сургалтын орчныг бүрдүүлсэн байх;
2.5. Үнэлгээ нь хүүхэд бүрийн хөгжил, ахицыг дэмжихөд чиглэсэн байх;	2.5. Үнэлгээ нь сурагч бүрд шударга хандаж, сурах үйл ажиллагаа, ахиц амжилтыг дэмжин, цаашид хөгжих боломжийг хангасан байх;
2.6. Эцэг эх, олон нийтийн оролцоог хангасан, бие даасан, нээлттэй, сургуулийн менежмент бодлогыг дэмжсэн байх гэх мэт.	2.6. Эцэг эх, олон нийт, сонирхлын бүлгийн оролцоог хангасан, бие даасан, нээлттэй, сургуулийн бодлого, менежментийг дэмжсэн байх гэх мэт. Харин сонирхлын бүлэг гэдэг хэр нийцтэй бол гэсэн хоёрдмол санаа үүсэж байв.

Хүснэгт 4-өөс сургалтын хөтөлбөрийн залгамж холбоог 6 ойлголтоор багцлан, ахих түвшинд авч үзсэн. Энэхүү сургалтын хөтөлбөрийн ахих түвшний харьцуулалтын залгамж холбоог бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн судлагдахуун бүрээр харьцуулж үзэхэд улам тодорхой харагдах болов уу хэмээн үзэж, улмаар баталгаажуулах үүднээс монгол хэлний хичээлээр бага, дунд боловсрол эзэмшихөд зорилго, зорилтыг, залгамж холбоонд нь бүдүүвчээр харьцуулав (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Монгол хэлний хичээлийн зорилго, зорилт ба эзэмших чадвар түүний онцлог

Бага боловсрол	Суурь боловсрол
Зорилго: Сурагч нь эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэн, бүтээлчээр уншиж, бичин, хэл соёлоороо бахархдаг болно.	Зорилго: Эх хэлний зохих шатны мэдлэгтэй, нийгмийн харилцааны тодорхой орчинд аман болон бичгийн хэлээр чадварлаг харилцдаг, хэлний мэдрэмжтэй, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг иргэн болж төлөвшинө.

Зорилт: 1. Монгол хэлний зүй, үгсийн сангийн анхан шатны мэдлэг ойлголт эзэмших, 2. Төрөл бүрийн эхийг уншиж, сонсож ойлгох, санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх арга барил эзэмших, 3. Эх хэлээрээ чадварлаг, соёлтой харилцах, үгийн сангаа нэмэгдүүлэх, хүсэл эрмэлзэлтэй болох гэх мэт.

Зорилт: 1. Хэл зүйн болон үгсийн сангийн зохих шатны мэдлэг, ойлголт эзэмшиж хэрэглэх чадвартай болох, 2. Уншиж, бичих, ярих-сонсох харилцааны чадвараа хөгжүүлэх, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хэрэглэх чадвар эзэмших, 3. Эх хэлний баялаг санг судлан эзэмших, бичиг соёлоо хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж, соёлын ялгаатай байдлыг ойлгож, хүндэтгэлтэй хандах хүсэл эрмэлзэлтэй болох гэх мэт.

Эзэмших чадвар: Хэлний хэрэглээнд тулгуурлан унших, бичих, ярих сонсох, хэл сурах арга барилд суралцана гэдэг ойлголт гарч байна.

Хүснэгт 5-д монгол хэлний хичээлээр олгох 4 чадвар нь бүхэлдээ ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сургалтын төлөвлөгөөгөөр судлах бүхий л хичээлд сайн сурах “түлхүүр” гэдэг утгыг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, уншиж, бичиж, сонсож, ярьдаггүй хичээл гэж нэг ч үгүй. Математик болон бусад хичээлээр жишиг болгон авч үзэв (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Бага, суурь боловсрол олгох математикийн хичээл хоорондын агуулгын холбоо хамаарал

Анги	Агуулга	Үр дүн
I-V, VI-IX	Тоо тоолол Хэмжигдэхүүн Геометр Өгөгдөлтэй ажиллах	Тухайн агуулгын тогтолцоо нь бүхэлдээ математикийн хэл суралцах, интеграцчилал хийх боломжтойг илрүүллээ.

Хүснэгт 6-д бусад хичээлтэй энэ мэтээр харьцуулахад энэхүү тогтолцоо нь бага, дунд ангийн байгаль, нийгмийн ухаан, урлаг, эрүүл мэнд, гадаад хэлний бүхий л хичээлд ижил туссан нь хичээл болон сэдвийг агуулгаар нь интеграцчилан авч үзэх боломжтой, илүү үр дүнтэй байна.

“Хүн ба орчин”, “Хүн ба нийгэм” хичээлээр харьцуулан үзэхэд дунд ангийн газар зүй, нийгмийн ухааны хичээлтэй хэрхэн холбогдож интеграциас, дифференциац судлагдахуун болон задарч буй нь бүр ч тодорхой болж байв. Жишиг болгон авч үзэв (Хүснэгт 7).

Хүснэгт 7. “Хүн ба орчин” хичээлийн агуулгын холбоо хамаарал (бага боловсрол)

Анги	Агуулга
I, II, III	Би: Хичээлийн хэрэглэлээ үүрэг зориулалтаар нэрлэх гэх мэт Миний бие: Мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар биеэ мэдрэх гэх мэт Миний гэр бүл: Өөрийн гэр бүлээ танилцуулах гэх мэт Миний гэр орон: Орчин тойрны зүйлстэй харьцуулж гэр, байраа танилцуулах гэх мэт Манай сургууль: Сургуулийн гадаад дотоод орчныг ялган таних гэх мэт Манай нутаг: Орон нутаг ба хүмүүс, орон нутаг ба байгалийн талаар ярих гэх мэт Манай дэлхий: Эх орон, эх дэлхий (өдөр шөнө, халуун хүйтэн улирал хүний амьдралд гэх мэт)

Хүснэгт 7-д байгаа сэдвүүд I-III ангид үзэх “Хүн ба орчин” хичээлийн агуулгыг залгамж холбоонд нь эрэмбэлэн “Би” гэдэг хувь хүнээс гэр бүл, нутаг орон, эх дэлхийн хүйн холбоотой гэдгийг нас биеийн онцлогт тохируулан боловсруулсан нь интеграц хичээл заахад нэн тохиромжтой нь харагдаж байна. Нэг талаараа ахих түвшин буюу дунд ангид газар зүйн хичээл болж дифференциац болон бүхэл байдлаар судлагдана.

Хүснэгт 8. “Хүн ба нийгэм” хичээлийн агуулгын сэдэв хоорондын холбоо хамаарал (бага боловсрол)

Анги	Агуулга
IV, V	Би, гэр бүл, сургуулийн амьдрал Нутгийн хүмүүс, нийгэм аж ахуй, соёлын амьдрал Хүмүүсийн харилцаа, хамтын амьдрал эрх үүрэг, хариуцлага, хууль эрх зүй

Хүснэгт 8-д байгаа 3 агуулга IV-V ангид судлах “Хүн ба нийгэм” хичээлийн агуулгыг хувь хүн ба нийгмийн харилцан хамаарлыг ахих түвшинд нь гүнзгийрүүлэн авч үзсэн нь сэдэв хоорондын залгамж холбоо бөгөөд энэ мэтчилэн дүрслэх урлаг технологи, хөгжим, биеийн тамир, эрүүл мэнд, гадаад хэлний хичээлийн залгамж холбоог гаргаж болох юм.

Ийнхүү судлагдахуун бүрийн агуулгыг харьцуулснаар багшийн заах сэдэв болон хичээл хоорондын залгамж холбоо тодорхой болж, багш суралцагч хоёрын хичээл бүрийн салангид ойлголт нэгдмэл болно.

Монгол хэлний хичээлээр хэд хэдэн ангид үздэг байсан авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүйг интеграцлан зааснаар агуулгын давхардлыг ариглаж, суралцахуй болон багшлахуйн ачааллыг зохистой болгохыг олж илрүүлсэн. Монгол хэлийг бүхий л судлагдахууны “цагаан толгой” гэж үзээд энэхүү ойлголтоо бусад хичээлтэй холбоход тодорхой байв. Өөрөөр хэлбэл бичихийн тул уншина, алдаагаа хянана, бусдад сонсоно, бусдыг сонсоно, хөрвүүлэх гэх мэт үйлүүд юм.

Математикийн хичээлд суралцах арга барил түүний онцлогийг авч үзэв (Хүснэгт 9). Ийн үзэхийн учир нь эх хэлний суралцахуйн чадвартай холбоход чиглүүлсэн болно.

Хүснэгт 9. Монгол хэлний хичээлийн унших, бичих, сонсох, ярих чадвар ба математикийн хичээл

Асуудал шийдвэрлэх арга барил		
4 түвшин ба 2 түвшин	VI-VII	VIII-IX
1. Асуудлыг олох, томъёолоход унших, бичих	Өдөр тутмын амьдрал дахь математикийн асуудлыг олох, ойлгох, өөрийн үгээр болон зураг, схемээр томъёолох	Нийгэм, ахуй амьдрал дахь математикийн асуудлыг олох, ойлгох, математик нэр томъёо, ойлголтоо ашиглан томъёолох
2. Асуудлыг математик загварт оруулах төлөвлөгөө боловсруулах, бодох, математик хэлд хөрвүүлж бичих	Шаардлагатай мэдээлэл цуглуулах, өмнөх туршлагатайгаа харьцуулах, жишээ олох, таамаглал дэвшүүлэх, асуудлыг математикийн хэлд хөрвүүлэх, төлөвлөгөө боловсруулах, алгоритм хэрэглэх гэх мэт	Шаардлагатай мэдээлэл, статистик тоо, баримт цуглуулах, хэрэгцээгүй мэдээлэл бий эсэхийг тогтоох, өмнөх туршлагатайгаа харьцуулах, ижил төстэй болон эсрэг жишээ олох, тодорхой үндэслэл таамаглал дэвшүүлэх, асуудлыг математик аргаар загварчлах, хувилбарт төлөвлөгөө боловсруулах гэх мэт
3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх буюу алхам бүрдээ хийж буй үйлдлээ алдаагүй үнэн зөв бичиж тэмдэглэх, тайлбарлан ярих	Төлөвлөгөөний алхам бүрийг гүйцэтгэх, хийж буй үйлдлээ алдаагүй үнэн зөв бичиж тэмдэглэх, тооцоолол хийх боломжийн тооцох, тухайн тохиолдлыг шалгах, диаграмм, график байгуулалтыг өгсөн нарийвчлалтай зурах, дүрслэх, тайлбарлах	Төлөвлөгөөний алхам бүрийг гүйцэтгэх, хянах, хийж буй үйлдлээ алдаагүй үнэн зөв бичиж тэмдэглэх, тооцоолол хийх боломжийг тооцох, үнэлэх, онцгой болон эсрэг тохиолдлыг шалгах, диаграмм, график байгуулалтыг тохирох нарийвчлалыг сонгон өөртөө болон бусдад ойлгомжтойгоор зурах, дүрслэх үндэслэлтэй тайлбарлах
4. Дүгнэлт гаргах, үр дүнг тайлбарлах, шийдсэн асуудал, дүгнэлтээ математик нэр томъёо, математик аргаар боловсруулах, үндэслэл зөв байх.	Дүгнэлтээ математик тэмдэглэгээ, нэр томъёо ашиглан тайлбарлах, дүгнэлтээ бусадтайгаа хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах, асуудлыг шийдвэрлэх өөр арга зам бий эсэхийг тодорхойлох, шийдсэн асуудалтай холбоотой өөр бодлого, асуудал дэвшүүлэх гэх мэт.	Дүгнэлтээ математик нэр томъёо, ойлголтоо ашиглан тодорхой үндэслэлтэй тайлбарлах, дүгнэлт нь асуудалд бүрэн хариулт өгч байгаа эсэхийг тооцох, дүгнэлтийг бусадтай хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах, асуудлыг шийдэх өөр арга зам бий эсэхийг тодорхойлох, шийдсэн асуудалтай холбоотой илүү өргөн, ерөнхий эсвэл явцуу асуудлыг дэвшүүлэх гэх мэт.

Хүснэгт 9-өөс VI-IX ангид арга зүйн талаас нь харьцуулахад а. суралцагч алхам тутамдаа алдаагүй зөв бичих, б. математикийн хэлд хөрвүүлж, математик аргаар загварчлах, в. томруулсан агуулгыг энгийн болгож зураг дүрслэлээр томъёолох, тулгуур дохио, бүдүүвчид оруулах, г. үр дүнг

үндэслэлтэй “тайлбарлах” гэсэн үг төгсгөл бүрд орсон зэрэг нь монгол хэлний чадвар математикийн сургалтад хэрхэн нөлөөлж, суралцагчдад ирэх хүндрэлийг ойлгомжтой болгохыг илтгэж байна.

Дээрх байдлаар багш нар сургалтын хөтөлбөрийн агуулгад харьцуулалт, анализ хийн интеграц хичээлээ бэлтгэн сургалтаа явуулж байв. Хичээлийн агуулгаа бэлтгэсний дараа багш нар 3 баг болж нэг нь хичээлээ заана. III улиралд нэг багш 3-4 удаа хичээл заасан. Хамгийн эхний хичээлийг сургалтын менежерийн баг заахаар төлөвлөн, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа хийсэн. Хичээлээ заасны дараа хэлэлцүүлгээ зохион байгуулж дараагийн хичээлийг сайжруулахад бэлтгэл ханган ажиллаж байв. Уг үйл ажиллагааны төгсгөлд хамгийн сайн болсон гэж үзсэн 3 хичээлийн бичлэг хийж орон нутгийн сургуулиудад илгээж, аймгийн телевизээр олон нийтэд шилдэг арга зүйгээ түгээн дэлгэрүүлсэн.

ҮР ДҮН

Энэхүү судалгааны үр дүнд сургалтын менежерүүд ажлын үндсэн чиг үүрэг дэх ажлаа бүрэн гүйцэтгэж чадахгүй, мөн сургалтын шинэлэг технологийг туршиж нэвтрүүлснээр багшийн хөгжил, суралцагчдын сурлагын амжилт дээшлэх боломжтойг харуулж байна.

1. Судалгаат интеграц хичээл зохион байгуулснаар суралцагчдын сурлагын амжилтад гарсан үр дүн

Хичээлийн жилийн төгсгөлд туршилтын 2, хяналтын 2, нийт 4 ангиас ижил агуулгаар шалгалт авч үр дүнг харьцуулав. Үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа судалгаат хичээлээр интеграцчилан заасан агуулгыг бүрэн хамруулахаар зорьсон. Монгол хэл 8, математик 8, нийгмийн ухаан 10, байгалийн ухаан 10, нийт 36 даалгаврыг сорил, задгай хэлбэрээр боловсруулан шалгалт авч үр дүнг тооцон харьцуулалт хийлээ. Үнэлгээг танин мэдэхүйн түвшинд нийцүүлэн суралцагчдын чадварыг үнэлэх блюпринт ашигласан.

Хүснэгт 10. Даалгаврын найдвартай байдал (Cronbach's Alpha)

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.841	.806	36

Даалгаврын найдвартай байдал сэдэв хоорондын нийц Cronbach's Alpha = 0.841 байна. Судалгаат интеграц хичээлийг зааснаар суралцагчийн сурлагын амжилтад хэрхэн нөлөөлснийг илрүүлэх зорилгоор хяналтын, туршилтын бүлгийн суралцагчдын хоорондох ялгааг шалгах T-test шинжилгээ хийсэн үр дүнг үзүүлэв (Хүснэгт 11).

Хүснэгт 11. T-test шинжилгээний үр дүн

Group statistics					
	Бүлэг	N	Mean	Std. Deviation	Std. Error Mean
Үнэлгээний дундаж	Туршилтын	112	80.02	8.216	1.208
	Хяналтын	106	65.87	8.176	1.256

Дээрх Хүснэгт 11-ээс харахад туршилтын бүлгийн үнэлгээний дундаж оноо M=80.02 нь хяналтын бүлгийн дундаж онооноос M=65.87 буюу 14.15%-аар өндөр байна.

Туршилтын болон хяналтын бүлгийн суралцагчдын мэдлэг, чадварын түвшний зөрөөг тодорхойлохын тулд эцсийн үнэлгээний үр дүнг T-тестээр шинжилсэн (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Үнэлгээний T-Test шинжилгээ, үр дүн

Independent Samples Test		
	Levene's Test for Equality of Variances	T-test for Equality of Means

		F	Sig.	T	df	Sig. (2tailed)	Mean Difference	Std. Error Difference	95% Confidence Interval of the Difference	
									Lower	Upper
Үнэлгээ дундаж	Equal variances assumed	.051	.786	5.03	96	.000	11.241	1.656	4.910	14.045
	Equal variances not assumed			5.03	96	.000	11.241	1.656	4.910	14.045

Хоёр бүлгийн үнэлгээний үр дүн $p < 0.001$ учраас статистикийн хувьд ялгаатай, туршилтын бүлгийн үнэлгээ нь 11.24 оноогоор илүү байгаа нь статистик ач холбогдолтой болох нь Хүснэгт 12-оос харагдаж байна. T-test шинжилгээний үр дүнгээс харахад интеграц хичээл нь суралцагчийн сурлагын амжилтыг дээшлүүлэхэд илүү үр дүнтэй байсныг баталж байна.

2. Судалгаат интеграц хичээл зохион байгуулснаар багшийн мэргэжлийн ур чадварт гарсан үр дүн
Судалгаат интеграц хичээлийн үйл ажиллагаанд хичээлийн жилийн турш 46 багш хамрагдсан. Тухайн багш нараас интеграц хичээл заахаас өмнө мэргэжлийн ур чадварын түвшний судалгаа авч түүнийгээ хичээл заасны дараах үр дүнтэй харьцуулан SPSS 26 программ ашиглан боловсруулж тооцлоо.

Хүснэгт 13. Paired Sample t-test (Хос хамааралтай t-шинжилгээ) үр дүн

Ур чадварын үзүүлэлт	Pre-test M (SD)	Post-test M (SD)	Ахиц %	t	p	Нөлөөллийн хэмжээ (d)
Хөтөлбөр боловсруулах, төлөвлөх	3.42 (0.49)	4.30 (0.45)	+25.7%	8.96	<.001	1.32
Заах арга зүй	3.25 (0.52)	4.18 (0.43)	+28.6%	9.45	<.001	1.40
Агуулга интеграц ба уялдаа холбоо	3.10 (0.47)	4.25 (0.39)	+37.1%	10.12	<.001	1.52
Хамтын ажиллагаа	3.38 (0.50)	4.28 (0.41)	+26.6%	9.02	<.001	1.34
Дижитал хэрэглээ	3.15 (0.56)	4.12 (0.46)	+30.7%	8.74	<.001	1.28
Үнэлгээ ба дэмжлэг	3.42 (0.48)	4.21 (0.44)	+23.1%	8.11	<.001	1.20
Нийт	3.29 (0.50)	4.22 (0.43)	+28.3%	9.73	<.001	1.48 (том)

Судалгаанд хамрагдсан 46 багшийн мэргэжлийн заах арга зүйн ур чадварын дундаж өмнө нь 3.29, дараа нь 4.22 болж, өсжээ. Энэ нь дунджаар 28.3%-ийн ахиц гарсныг илтгэж байна. Paired Sample t-test-ийн үр дүнгээр бүх үзүүлэлтэд $p < .001$ буюу статистикийн хувьд утга бүхий ялгаа гарсан. Хамгийн их ахиц үзүүлсэн чадвар нь интеграц ба уялдаа холбоо ($d = 1.52$) бөгөөд энэ нь интеграц хичээл заах үйл ажиллагаа нь багшийн хичээл хоорондын уялдаа, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх арга зүйг хамгийн их хөгжүүлсэн болохыг харуулж байна. Харин дижитал хэрэглээ болон суралцагч төвтэй арга зүй мөн 30%-ийн, хамтын ажиллагаа ба төлөвлөлт 25%-ийн өсөлттэй гарсан нь интеграц сургалт зөвхөн мэдлэг төдийгүй багшийн практик ур чадварыг өргөн хүрээнд хөгжүүлснийг нотолж байна. Интеграц хичээлд оролцсон багш нарын мэргэжлийн ур чадвар бүх чиглэлээрээ статистикийн хувьд утга бүхий хэмжээгээр ($p < .001$) сайжирсан бөгөөд, нөлөөллийн хэмжээ их түвшинд ($d > 1.2$) байна. Тухайлбал, интеграц хичээлийн туршлагатай болсноор багшид хичээл төлөвлөх, суралцагч төвтэй арга зүй хэрэглэх, хичээл хоорондын уялдаа холбоо бий болгох, хамтран ажиллах, дижитал хэрэглээ, үнэлгээ дэмжлэг үзүүлэх чадвар бүгд мэдэгдэхүйц дээшилснийг харууллаа.

3. Сургалтын менежер судалгаат интеграц хичээлийг зохион байгуулж хэрэгжүүлснээр үндсэн ажлын хэрэгжилт болон өөрийнх нь хөгжилд гарсан үр дүн

а. Үндсэн ажлын хэрэгжилтийн үр дүн: Интеграц хичээлийн үйл ажиллагааг зохион байгуулснаар сургалтын менежерийн үндсэн чиг үүрэг болох сургалтын төлөвлөлт, хяналт-шинжилгээ, дотоод

үнэлгээ, багшийн дэмжлэг, арга зүйн зөвлөмж өгөх үйл ажиллагаа илүү системтэй болсон байна. Дундаж үнэлгээ (М)-ээр үзэхэд: үйл ажиллагааны зохион байгуулалт Pre-test M=3.45, Post-test M=4.35, ахиц +26.1%, $p<.001$, хяналт-шинжилгээ, үнэлгээний чанар Pre-test M=3.38, Post-test M=4.30, ахиц +27.2%, $p<.001$ байгаа нь сургалтын менежерийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр ашиг нэмэгдэж, хяналт илүү бодитой, нотолгоонд тулгуурласан хэлбэрт шилжсэнийг харуулж байна. Интеграц хичээл хэрэгжүүлэх хугацаанд сургалтын менежер багш нарын хичээлийн уялдаа холбоог дэмжих, хичээлийн төлөвлөлтийг интеграцчилах, дотоод хяналт-шинжилгээ хийх ажлыг төлөвлөгөөтэй удирдаж чадсан. Зохион байгуулсан үйл ажиллагаа нь зөвхөн хичээлийн чанарт бус, багш-менежер-суралцагчийн хамтын уялдаа, бүтээлч сэтгэхүйн хөгжилд хүчтэй эерэг нөлөө үзүүлснийг нотолж байна.

Хүснэгт 14. 6. Менежерийн хувийн хөгжил

Хөгжлийн чиглэл	Pre-test M	Post-test M	Ахиц %	p
Удирдлагын төлөвлөлт	3.40	4.35	+27.9%	<.001
Хүний нөөцийн дэмжлэг, зөвлөн чиглүүлэх чадвар	3.32	4.28	+28.9%	<.001
Судалгаанд суурилсан дүн шинжилгээ хийх чадвар	3.10	4.21	+35.8%	<.001
Өөрийн хөгжлийн рефлекс ба үнэлгээ	3.25	4.24	+30.5%	<.001

Нийт дундаж өсөлт: +30.8% ($d = 1.49$)

Судалгаат интеграц хичээлийн үйл ажиллагаанд сургалтын менежерийн оролцоо нь сургуулийн менежментийн чиг үүргийн хэрэгжилтийг сайжруулж сургалтын чанар ба багшийн ур чадварт эерэг нөлөө үзүүлж менежерийн өөрийн удирдлагын, судалгааны, зөвлөн чиглүүлэх ур чадварыг мэдэгдэхүйц өсгөсөн байна. SPSS-ийн үр дүнгээр эдгээр бүх чиглэлд статистикийн хувьд утга бүхий ахиц ($p<.001$) илэрсэн нь интеграц хичээлийн үйл ажиллагаа сургалтын менежерийн мэргэжлийн хөгжлийг бодитой дэмждэг арга зүй болохыг харуулж байна.

Судалгаат интеграц хичээлийг зохион байгуулснаар сургалтын менежерийн ирлүүлсэн асуудлууд:

- Бодлого төлөвлөлтийн оновчтой хийх.
- Бага боловсролд хүүхэд бүрийг хоцрогдолгүй сургахад чиглэсэн багш суралцагчид агуулгыг хугацаатай, тодорхой гаргаж бодлогын хөтөлбөртөө тусгах, хяналтын график байгуулан үр дүнг тооцон ажиллах.
- Жил бүрийн стандарт биелэлт, суралцагчийн үнэлгээнд тулгуурлан дараагийн хичээлийн жилийн зорилгыг тодорхойлж хэвших.
- Бага ангийн суралцагчийн хамгийн чухал зүйл бол унших, ойлгох чадвартай болох, зөв хандлагатай, сурах арга барилаа эзэмших.
- Багш, хичээлийн агуулгыг интеграцчилан зааж бататгах, хоцрогдлоо нөхөх цаг гаргадаг зөв шийдлийг олж харах.
- Багш бүр өөрийн брэнд арга зүйтэй болох, өөрийн арга зүйгээ сайжруулан ажлын байрандаа хөгжих, ахмад залуу үеийн залгамж холбоог сайжруулах, ахмадаасаа суралцах зэргээр багш бүр агуулгын интеграцийг гаргуулан, хүүхдийн хоцрогдлыг богино хугацаанд агуулгын интеграциар нөхөн ажилласнаар бага, дунд боловсролын сургалтын чанарыг нэмэгдүүлэх

Дээрх үйл ажиллагаанаас дүгнэхэд менежер сургалтын технологийг шинэчлэн сайжруулах чиглэлээр дараах ажлыг хийх шаардлагатай байна гэж үзлээ. Үүнд:

- Хичээлийн технологийг шинэчлэхтэй холбоотой материалыг багш нараар судлуулах, ярилцлага зохиох;
- Багш нарын хамтын хичээл (бага, дунд ангийн багш нар сэдвийн агуулгын залгамж холбоогоор интеграц, төсөлт хичээл гэх мэт) зохион байгуулах;
- Бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх аргыг сургалтад хэрэглэх, хэсгээр сургалт зохион байгуулах, хичээлийн явцад мэдээллийн сан байгуулах зэрэг тулгамдсан асуудлаар багш нарын дунд сургалт зохион байгуулах;
- Багш нарын туршлагыг нийтийн хүртээл болгох ажлыг зохион байгуулах;
- Анги дүүргэлтийг зохицуулах;

- Ижил бүлэгт заадаг багш нар хүүхдэд зориулсан даалгавар дасгалыг хамтарч бэлтгэдэг, гэрийн даалгаврыг сонгох хэлбэрээр өгөх;
- Ихэнх сургуульд ахмад, залуу, ижил бүлэгт заадаг багш нарын хамтын ажиллагааг дэмжих, бага, дунд ангийн багш нарын хамтын ажиллагаанд ахиц гаргах;

Судалгаат хичээлийн явцад багш нар ангиа солин хичээл зааж, шалгалтын сэдвээ хамтарч бэлтгэдэг болсон зэрэг нь “Хаана эв байна, тэнд дандаа ялалт байна” гэсэн сургаал үгийн утгыг харуулж байв. Сургалтын менежер, заах аргын нэгдлийн ахлагчид өөрсдөө үлгэрлэн хамтдаа хичээл зааж харилцан зөвлөлдөж байв. Мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулан бага, дунд ангийн хичээл хоорондын залгамж холбоог тогтолцоогоор авч үзэж байв. Зарим тохиолдолд амжилт гаргасан хэдий ч тэр нь өөрийн болж чадаагүйг олж харан бие биеийнхээ сул талыг засахад чиглүүлэх бодлого баримталж ажиллав.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судалгаагаар сургалтын менежер үндсэн ажлаа бодитой үр дүнтэй гүйцэтгэх арга нь судалгаат интеграц хичээлийг зохион байгуулах шинэлэг сургалтын технологийг хэрэгжүүлсэн зарим үр дүнд шинжилгээ хийж, суралцагчдын сурлагын амжилт, багшийн мэргэжлийн ур чадвар, менежерийн ажлын гүйцэтгэл, хөгжилд нөлөөлж буй нөлөөллийг судлав. Интеграц хичээл хэрэгжүүлсний дараа суралцагчдын сурлагын амжилтыг судлахад мэдлэгийн түвшин ойролцоо бүлгүүдийн туршилтын бүлгийн дундаж оноо хяналтын бүлгийнхээс статистик ач холбогдолтой ялгаа байгаа нь харагдсан. Эндээс интеграц хичээлийн арга зүй нь суралцагчдын сурлагын амжилтад эерэг нөлөө үзүүлж байна (Хүснэгт 11). Мөн багшийн мэргэжлийн ур чадварт гарсан өөрчлөлтийг интеграц хичээл зохион байгуулахаас өмнөх болон дараах үр дүнг харьцуулан судлахад багшийн мэргэжлийн ур чадварт эерэг нөлөө үзүүлж байв (Хүснэгт 13). Сургалтын менежер судалгаат интеграц хичээлийн шинэлэг технологийг туршин нэвтрүүлсэн нь менежерийн үндсэн ажлын зорилго хангагдаж багшлахуй болон суралцахуйд бодитой эерэг үр дүн гарлаа.

Туршилтад бага, дунд ангийн 4-оос илүү анги хамруулах боломжгүй байсан нь судалгааны ажлын хязгаарлагдмал тал байж болно. Мөн туршилттай холбоотой ижил төрлийн судалгаа дутагдалтай байгаагаас харьцуулалт хийх боломж хязгаарлагдсан. Цаашдын судалгаанд интеграц сургалтын арга зүйг сургууль бүр хэрэгжүүлэн хэрэгжилт, үр нөлөөг судалж, багш, суралцагчдын бэлэн байдал, оролцоо, үр дүнг нарийвчлан судлах хэрэгцээ байна гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

Сургалтын менежер үндсэн чиг үүргийн ажлаа бүрэн гүйцэтгэж чадахгүй байгааг дурдсан судалгааны үр дүнгүүд багагүй байгаа боловч энэхүү судалгаагаар сургалтын шинэлэг технологийг туршиж нэвтрүүлснээр багшийн хөгжил, суралцагчдын сурлагын амжилт дээшлэх боломжтойг харуулж байна.

Судалгааны үр дүнгээ сургуулийн удирдлагын зөв бодлого, оновчтой төлөвлөлт, үйл ажиллагаа чухал болохыг уг интеграц сургалтын үр дүнг суралцагчдын сургалтын амжилт, багшийн мэргэжлийн заах ур чадвар, сургалтын менежерийн үндсэн ажлын үр дүн, хөгжил зэргээр нотлон харууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад хэрэгжүүлсэн интеграц хичээлийн арга зүй нь суралцагчийн сурлагын амжилтыг дээшлүүлэхэд нөлөөтэй болохыг илтгэж байна.

Судалгаанд хамрагдсан багшийн мэргэжлийн заах арга зүйн ур чадварын нийт дундаж өмнө нь 3.29, дараа нь 4.22 болж өссөн байна. Энэ нь дунджаар 28.3%-ийн ахиц гарсан байна. Paired Sample t-test-ийн үр дүнгээр бүх үзүүлэлтүүдэд $p < .001$ буюу статистикийн хувьд утга бүхий ялгаа гарсан. Хамгийн их ахиц үзүүлсэн чадвар нь интеграц ба уялдаа холбоо ($d=1.52$) бөгөөд энэ нь интеграц хичээл заах үйл ажиллагаа нь багшийн хичээл хоорондын уялдаа, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх арга зүйг хамгийн их хөгжүүлсэн болохыг харуулж байна. Харин дижитал хэрэглээ болон суралцагч төвтэй арга зүй мөн 30%-ийн, хамтын ажиллагаа ба төлөвлөлт 25%-ийн өсөлттэй гарсан нь интеграц сургалт нь зөвхөн мэдлэг төдийгүй багшийн практик ур чадварыг өргөн хүрээнд хөгжүүлснийг нотолж байна. Интеграц хичээлд оролцсон багш нарын мэргэжлийн ур чадвар бүх чиглэлээрээ статистикийн хувьд утга бүхий хэмжээгээр ($p<.001$) сайжирсан бөгөөд, нөлөөллийн хэмжээ их түвшинд ($d>1.2$) байна. Интеграц хичээлийн туршлагатай болсноор багшид хичээл

төлөвлөх, суралцагч төвтэй арга зүй хэрэглэх, хичээл хоорондын уялдаа холбоо бий болгох, хамтран ажиллах, дижитал хэрэглээ, үнэлгээнд дэмжлэг үзүүлэх чадвар бүгд мэдэгдэхүйц дээшилснийг харууллаа. Интеграц хичээлийн үйл ажиллагааг зохион байгуулснаар сургалтын менежерийн үндсэн чиг үүрэг болох сургалтын төлөвлөлт, хяналт-шинжилгээ, дотоод үнэлгээ, багшийн дэмжлэг, арга зүйн зөвлөмж өгөх үйл ажиллагаа илүү системтэй болсон байна.

Үйл ажиллагааны зохион байгуулалт Pre-test M=3.45, Post-test M=4.35, ахиц +26.1%, $p<.001$, хяналт-шинжилгээ, үнэлгээний чанар Pre-test M=3.38, Post-test M=4.30, ахиц +27.2%, $p<.001$ байгаа нь сургалтын менежерийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр ашиг нэмэгдэж, хяналт илүү бодитой, нотолгоонд тулгуурласан хэлбэрт шилжсэнийг харуулж байна. Интеграц хичээл хэрэгжүүлэх хугацаанд сургалтын менежер багш нарын хичээлийн уялдаа холбоог дэмжих, хичээлийн төлөвлөлтийг интеграцчилах, дотоод хяналт-шинжилгээ хийх ажлыг төлөвлөгөөтэй удирдаж чадсан. Энэ нь түүний зохион байгуулсан интеграц үйл ажиллагаа нь зөвхөн хичээлийн чанарт бус, багш-менежер-суралцагчийн хамтын уялдаа, бүтээлч сэтгэхүйн хөгжилд хүчтэй эерэг нөлөө үзүүлснийг нотолж байна.

ЗОХИОГЧДЫН ОРОЛЦОО

Онолын үндэс, санаа: Б.Л., Я.Ш; **Арга зүй:** Я.Ш., Ц.П; **Мэдээлэл цуглуулалт:** Б.Л., Ц.П, **Боловсруулалт:** Ц.П, **Бичилт (эхний хувилбар):** Б.Л, Ц.П.; **Бичилт (засвар):** Б.Л., Я.Ш; **Хяналт:** Б.Л., Я.Ш; **Мэргэжлийн удирдлага:** Я.Ш., Б.Л

НОМ ЗҮЙ

Өгүүлэл

Бямбажав, Г. (2016). Боловсролын удирдах ажилтнуудын нөхцөл байдлын манлайллын хэв маягийг тогтоох судалгаа. *Лавай сэтгүүл*, 14(15), 60-66

Нарантуяа, Ж. (2004). Амжилтад хүрэх удирдагч буюу боловсролын менежерийн хөрөг. *Боловсрол судлал сэтгүүл*, 3(14). 14-20

Уянга, Б. (2016). Орчин үеийн боловсролын удирдах ажилтны манлайллын нөлөөг сайжруулах зарим асуудалд. *Лавай сэтгүүл*, 14 (14), 153-158

Пагмадулам, И, Өлзийсайхан, Г (2023). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн хөгжих хэрэгцээний судалгаа. *Лавай сэтгүүл*, No. 29 15-29

Наранчимэг, Н. (2017). ЕБС-ийн удирдах ажилтны манлайллын чадварыг LPI арга ашиглан судалсан дүн. *Боловсрол судлал сэтгүүл*, 06 (134), 14-21

Ном

Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт. Наранчимэг, Н. (1999) “Сургалтын технологийн удирдлага” УБ. Хуудас 241-267

Хөхөө, Д. (2002) “Сургууль түшиглэсэн хичээл хоорондын холбоо” УБ.

Батхуяг, С. (2002). Орчин үеийн сургуулийн удирдлага. УБ.

Пүрэв, О. (2015). Манлайллын чадварт боловсролын гүйцэтгэх үүрэг. УБ.

Ичинхорлоо.Ш. (2019). *Сурахуй хийгээд сурах арга* . УБ.

Нямсүрэн,Ц., Уртнасан,Г., Бадамсүрэн,Б. (2024). Асуудалд суурилсан сургалтын арга зүйг туршсан үр дүн. *Математик, байгалийн ухаан*, 51-61

Armstrong, D. (2009). Administrative passages: Navigating the transition from teaching to administration. Dordrecht, Netherlands: Springer-Verlag.

Тайлан

Үндэсний статистикийн хороо [ҮСХ]. (2025). *Хөвсгөл аймгийн статистикийн тооллого: Үндсэн үр дүн*. Улаанбаатар, Монгол Улс. Татаж авсан холбоос <http://www.1212.mn>

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл

Ариунгэрэл, С. (2020). ЕБС-ийн сургалтын менежерийн ажлын чиг үүрэг ба хэрэгжилт. Боловсролын тулгамдсан асуудал, шийдэл, арга зам эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 6, 73-80.

БМДИ, МХСН. (2014-2016). “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” сэдэвт онол практикийн II-IV бага хурлын эмхэтгэл, УБ.

Milana, M., & Skrypnyk, O. (2009, June 29-30). *Professionals vs. role professionals: Conceptualizing professionalism among teachers of adults* [Conference session]. Teachers and Trainers in Adult Education and Lifelong Learning: Professional Development in Asia and Europe, Bergisch Gladbach, Germany.

Хууль

Боловсролын ерөнхий хууль 2023 (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

Боловсролын үнэлгээний төв. (2018). "ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг хэрэгжүүлэх зөвлөмж. УБ.

Сургалтын хөтөлбөр

БШУЯ, (2019). “Бага боловсролын сургалтын хөтөлбөр” сайжруулсан хоёр дахь хэвлэл. УБ

БШУЯ, (2019). “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр” сайжруулсан хоёр дахь хэвлэл. УБ

Бусад

Ганбаатар Т. (2013). Багшлахуйн хөгжил: Хичээлийн судалгааны арга зүйн үндэс, УБ., 9-23

Ганбаатар Т. (2017). Хичээлийн судалгаа, ач холбогдол, үр дүн (ТХБ төслийн захиалгат сургалтын ppt), МУБИС., УБ.

Оюунцэцэг Н. (2017). Хичээлийн судалгааны үр дүнг тайлагнах илтгэл бичих зөвлөмж, (ТХБ төслийн захиалгат сургалтын ppt), МУБИС., УБ.

Диссертаци

Рэнцэнханд, Ц. (2010). *Сургалтын технологийн шинэчлэлийн үе дэх сургалтын менежерийн үйл ажиллагааг судалсан нь. Докторын диссертаци*, Улаанбаатар. МУБИС.

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Цэдэн-Очир Пагмажав
 <https://orcid.org/0009-0005-2334-4417>
Байгууллагын нэр: МУБИС
Хаяг: Улаанбаатар хот-14191,
СБД, 8 дугаар хороо, Бага тойруу-14
Улс: Монгол
e-mail: ms.pagmajav@gmail.com

Овог, нэр: Яйш Шийлэгмаа
 <https://orcid.org/0009-0007-8572-7100>
Байгууллагын нэр: МУБИС
Хаяг: Улаанбаатар хот-14191,
СБД, 8 дугаар хороо, Бага тойруу-14
Улс: Монгол
e-mail: shiilegmaa@msue.edu.mn

Овог, нэр: Баатар Лхагвамаа
 <https://orcid.org/0009-0003-9959-0425>
Байгууллагын нэр: УБЭИС Е-Нээлттэй сургууль
Хаяг: Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу,
Ялалтын талбайн зүүн талд
Улс: Монгол
e-mail: Lkhagii0133@gmail.com
